



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мөнххаан сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/114/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт сум 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 99029193 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Даваа Утас: 99035990 Цахим хаяг: davaag@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Ариунбаяр Утас: 99076224 Цахим хаяг: ariunbayars@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	12
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Албан шаардлага	13
4.2 Зөвлөмж	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
НББ	Нягтлан бодох бүртгэл
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.02.25 № 55
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН МӨНХХААН
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.АРИУНМӨНХ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөнххаан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мөнххаан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Мөнххаан сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>10,196,844.00</u>	<u>14,176,215.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	10,196,844.00	14,176,215.00
351	Түүхий эд материал	3,731,250.00	4,998,200.00
35110	Тусгай зориулалттай материал	3,731,250.00	4,998,200.00
354	Хангамжийн материал	6,465,594.00	9,178,015.00
35420	Аж ахуйн материал	5,759,494.00	8,596,015.00
35440	Түлш, шатах тослох материал	193,600.00	00.00
35460	Хүнсний материал	48,500.00	118,000.00
35470	Бусад хангамжийн материал	464,000.00	464,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,155,348,155.27</u>	<u>1,151,509,481.93</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,155,348,155.27	1,151,509,481.93
392	Биет хөрөнгө	1,143,670,155.27	1,139,831,481.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,147,290,320.85	1,147,290,320.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	-55,674,415.44	-83,511,623.16
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	44,648,690.50	52,129,680.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-23,727,829.06	-28,870,524.88
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,107,525.00	79,712,525.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-27,899,001.53	-34,530,386.41
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,095,000.00	8,095,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,247,135.05	-2,696,509.97
39217	Ном	2,077,000.00	2,213,000.00
393	Биет бус хөрөнгө	11,678,000.00	11,678,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,678,000.00	11,678,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,165,544,999.27</u>	<u>1,165,685,696.93</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,165,544,999.27</u>	<u>1,165,685,696.93</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,165,544,999.27	1,165,685,696.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	56,737,040.00	56,737,040.00
51101	Өмч: - төрийн	56,737,040.00	56,737,040.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,048,075,677.89	1,048,216,375.55
51210	Өмнөх үеийн үр дүн	1,048,075,677.89	1,048,075,677.89
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	140,697.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	60,732,281.38	60,732,281.38
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,165,544,999.27</u>	<u>1,165,685,696.93</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	616,098,000.00	630,863,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,499,000.00	73,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,499,000.00	73,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	68,808,800.00	84,088,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	543,790,200.00	546,700,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	160,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	160,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	68,808,800.00	83,928,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	68,808,800.00	83,928,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	634,011,465.53	630,722,402.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	634,011,465.53	630,722,402.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	631,080,922.09	630,656,566.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	410,192,017.46	410,534,923.94
210101	Үндсэн цалин	255,451,682.97	312,169,523.94
210102	Нэмэгдэл	101,838,300.00	75,186,830.40
210104	Урамшуулал	39,433,834.49	23,178,569.60
210105	Гэрээт ажлын хөлс	13,468,200.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,901,300.00	55,231,600.00
210201	Тэтгэврийн даатгал	36,271,700.00	39,088,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,157,400.00	4,035,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,325,900.00	3,228,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	831,400.00	807,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,314,900.00	8,071,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,045,852.10	51,630,237.86
210301	Гэрэл, цахилгаан	6,170,888.10	5,045,256.46
210302	Түлш, халаалт	34,548,764.00	35,180,835.10
210303	Цэвэр, бохир ус	18,326,200.00	11,404,146.30
2104	Хангамж, бараа материалын зардал	1,746,581.00	1,551,850.00
210401	Бичиг хэрэг	170,100.00	379,700.00
210402	Тээвэр, шатахуун	893,631.00	357,150.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	137,600.00	375,000.00
210404	Ном, хэвлэл	58,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	487,250.00	440,000.00
2105	Нормативт зардал	53,871,400.00	42,850,850.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,513,500.00	190,000.00
210502	Хоол, хүнс	50,434,900.00	41,207,350.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	923,000.00	1,453,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,999,960.00	12,618,760.00
210604	Урсгал засвар	9,999,960.00	12,618,760.00
2107	Томиллолт, зочны зардал	156,000.00	117,000.00
210702	Дотоод албан томиллолт	156,000.00	117,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,611,100.00	6,321,502.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,611,100.00	6,321,502.00

Мөнххаан сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,556,711.53	49,799,842.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,000.00	1,510,879.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,697,350.00	8,228,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,839,361.53	40,060,663.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,930,543.44	65,836.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	487.90	00.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	487.90	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	312.14
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	312.14
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,930,055.54	65,524.06
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,930,055.54	65,524.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-17,913,465.53</u>	<u>140,697.66</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-17,913,465.53</u>	<u>140,697.66</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	56,737,040.00	60,732,281.38	1,048,075,677.89	1,165,544,999.27
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	56,737,040.00	60,732,281.38	1,048,075,677.89	1,165,544,999.27
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	56,737,040.00	60,732,281.38	1,048,075,677.89	1,165,544,999.27
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	140,697.66	140,697.66
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	56,737,040.00	60,732,281.38	1,048,216,375.55	1,165,685,696.93

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	612,599,000.00	630,789,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	612,599,000.00	630,789,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	543,790,200.00	546,700,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	160,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	160,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	68,808,800.00	83,928,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	68,808,800.00	83,928,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	601,983,580.00	594,567,510.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	601,983,580.00	594,567,510.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	599,053,036.56	594,501,673.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	410,192,017.46	410,534,923.94
210101	Үндсэн цалин	255,451,682.97	312,169,523.94
210102	Нэмэгдэл	101,838,300.00	75,186,830.40
210104	Урамшуулал	39,433,834.49	23,178,569.60
210105	Гэрээт ажлын хөлс	13,468,200.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,901,300.00	55,231,600.00
210201	Тэтгэврийн даатгал	36,271,700.00	39,088,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,157,400.00	4,035,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,325,900.00	3,228,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	831,400.00	807,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,314,900.00	8,071,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,808,352.10	51,428,287.86
210301	Гэрэл, цахилгаан	6,170,888.10	5,045,256.46
210302	Түлш, халаалт	34,311,264.00	34,978,885.10
210303	Цэвэр, бохир ус	18,326,200.00	11,404,146.30
2104	Хангамж, бараа материалын зардал	3,448,489.00	1,571,610.00
210401	Бичиг хэрэг	169,800.00	453,400.00
210402	Тээвэр, шатахуун	889,131.00	350,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	137,600.00	375,000.00
210404	Ном, хэвлэл	58,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,193,958.00	393,210.00
2105	Нормативт зардал	56,661,280.00	43,390,250.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,088,800.00	160,400.00
210502	Хоол, хүнс	51,874,580.00	41,276,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,697,900.00	1,953,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,099,960.00	12,522,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	100,000.00	00.00
210604	Урсгал засвар	9,999,960.00	12,522,000.00
2107	Томилолт, зочны зардал	156,000.00	117,000.00
210702	Дотоод албан томилолт	156,000.00	117,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,656,200.00	6,032,102.00

Мөнххаан сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,656,200.00	6,032,102.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,129,438.00	13,673,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	893,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,129,438.00	12,780,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,930,543.44	65,836.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	487.90	00.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	487.90	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	312.14
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	312.14
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт,	2,930,055.54	65,524.06
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,930,055.54	65,524.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	10,615,420.00	36,221,990.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	10,615,420.00	36,221,990.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,615,420.00	36,221,990.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,615,420.00	36,221,990.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,615,420.00	36,221,990.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-10,615,420.00	-36,221,990.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	630,623,500.0	630,563,663.8	59,836.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	630,623,500.0	630,563,663.8	59,836.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	630,623,500.0	630,563,663.8	59,836.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	410,566,900.0	410,534,923.9	31,976.1
210101	Үндсэн цалин	312,201,500.0	312,169,523.9	31,976.1
210102	Нэмэгдэл	64,793,200.0	75,186,830.4	10,393,630.4
210104	Урамшуулал	33,572,200.0	23,178,569.6	10,393,630.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,231,600.0	55,231,600.0	-
210201	Тэтгэврийн даатгал	39,088,900.0	39,088,900.0	-
210202	Тэтгэмжийн даатгал	4,035,700.0	4,035,700.0	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,228,500.0	3,228,500.0	-
210204	Ажилгүйдлийн даатгал	807,200.0	807,200.0	-
210205	Эрүүл мэндийн даатгал	8,071,300.0	8,071,300.0	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,428,600.0	51,428,287.9	312.1
210301	Гэрэл, цахилгаан	6,828,600.0	5,045,256.5	1,783,343.5
210302	Түлш, халаалт	33,100,000.0	34,978,885.1	-1,878,885.1
210303	Цэвэр, бохир ус	11,500,000.0	11,404,146.3	95,853.7
2104	Хангамж, бараа материалын зардал	1,621,300.0	1,595,610.0	25,690.0
210401	Бичиг хэрэг	453,400.0	453,400.0	-
210402	Тээвэр, шатахуун	350,000.0	350,000.0	-

Мөнххаан сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	354,300.0	375,000.0	-20,700.0
210404	Ном, хэвлэл	104,600.0	24,000.0	80,600.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	359,000.0	393,210.0	-34,210.0
2105	Нормативт зардал	43,391,700.0	43,390,250.0	1,450.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	160,400.0	160,400.0	-
210502	Хоол, хүнс	41,278,300.0	41,276,850.0	1,450.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,953,000.0	1,953,000.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,500,000.0	32,500,000.0	-
210604	Урсгал засвар	32,500,000.0	32,500,000.0	-
2107	Томилолт, зочны зардал	117,000.0	117,000.0	-
210702	Дотоод албан томилолт	117,000.0	117,000.0	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,872,300.0	5,872,102.0	198.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,872,300.0	5,872,102.0	198.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,894,100.0	29,893,890.0	210.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	893,000.0	893,000.0	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,001,100.0	29,000,890.0	210.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	630,623,500.0	630,563,663.8	59,836.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	546,694,900.0	546,635,375.9	59,524.1
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	546,694,900.0	546,635,375.9	59,524.1
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	83,928,600.0	83,928,287.9	312.1
132001	Орон нутгийн төсвөөс	83,928,600.0	83,928,287.9	312.1

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	төлөвлөгөө	Гүйцэтгэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		160,000.0	(160,000.0)
21	УРСГАЛ ЗАРДАЛ		160,000.0	(160,000.0)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		160,000.0	(160,000.0)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		160,000.0	(160,000.0)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		160,000.0	(160,000.0)
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	160,000.0	(160,000.0)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		160,000.0	(160,000.0)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		160,000.0	(160,000.0)

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мөнххаан сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Ариунбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мөнххаан сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 1/57 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөнххаан сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Мөнххаан сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 630,722.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,460.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,095.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мөнххаан сумын цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 140.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /мянган төгрөг/
Бараа материал	10,196.8	14,176.2	3,979.4
Үндсэн хөрөнгө	1,155,348.2	1,151,509.5	(3,838.7)
Нийт хөрөнгө	1,165,545.0	1,165,685.7	140.7
Засгийн газрын хувь оролцоо	1,165,545.0	1,165,685.7	140.7
Хуримтлагдсан үр дүн	1,048,075.7	1,048,216.4	140.7
Тайлант үеийн үр дүн	-	140.7	140.7
Өр төлбөр, цэвэр өмчийн дүн	1,165,545.0	1,165,685.7	140.7

Бараа материал данс өмнөх оноос 3,979.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд 94,714.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 90,735.2 мянган төгрөгийн материал зарцуулсан бөгөөд аж ахуйн зориулалттай материал худалдан авч үлдээгдлээр тайлагнасан нь бараа материал дансны үлдэгдэл нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө данс өмнөх оноос 3,838.7 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 7,480.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 28,605.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авч данс бүртгэлд тусгасан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 546,694.9 мянга, орон нутгийн төсвөөс 83,928.3 мянга нийт 630,623.5 мянган төгрөгийг төлөвлөж, бүрэн санхүүжүүлсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн нийт зарлагыг 630,563.7 мянган төгрөгөөр илэрхийлж төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 59.8 мянган төгрөгийг дээд шатны төсвийн захирагчийн дансанд төвлөрүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэлээр гарсан нийт зардлын 465,766.5 мянган төгрөг буюу 73.8 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоо нийгмийн даатгалд төлөх шимтгэл эзэлж байгаа бол 164,797.2 мянган төгрөг буюу 26.2 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал зэрэг бусад зардлууд эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын код СБА-2022/114/НА-СТА-ТШЗ

3.6.2 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Мөнххаан сумын цэцэрлэгийн нэмэлт санхүүжилтийн дансаар 160.0 мянган төгрөг төвлөрч, уг хөрөнгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 10 зорилтын хүрээнд 74 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Төлөвлөгөөний хэрэгжилтийг 88.3 хувьтай тайлагнасан бөгөөд зарим төлөвлөсөн арга хэмжээг ковид цар тахлын улмаас хэрэгжүүлээгүй байна.

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал ажиглагдаагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим сайтад мэдээлбэл зохих мэдээллээс 135 мэдээллийг хугацаанд нь 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Харин таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 зарлагын гүйлгээний 25,911.0 мянга, урсгал санхүүжилтийн 35 гүйлгээний 616,106.7 мянган төгрөгийг мэдээлээгүй тул албан шаардлага хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байгаа боловч зарим мэдээллийг хангалтгүй байршуулсан гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд

чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан байна. Тухайлбал:

- Тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”
- Тогтоолын 1.8-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; гэж заасан байна”

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,160.4 мянган төгрөгийн төлбөрийн акт, 1,055.5 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, дотоод хяналт, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой 2 зөвлөмж хүргүүлж, шийдвэрийн биелэлтийг 2021 онытоот албан бичгээр ирүүлсэн байна. Төлбөрийн акт, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн боловч шилэн дансны мэдээллийг цахимд хугацаанд нь мэдээлэх талаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байна.

Иймд өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага 100 хувь, зөвлөмж 50.0 хувьтай хэрэгжсэн байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 61,890.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 36,085.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 25,804.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Албан шаардлага

- *Тайлант онд төсвийн хөрөнгөөр 7,480.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 28,605.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авч төсвийг арвилан хэмнэлтгүй захиран зарцуулсан байна.*

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1¹, 41 дүгээр зүйлийн 41.2.3², Засгийн газрын 2021 оны 43³ дугаар тогтоолын 1.4⁴-т заасныг зөрчиж тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна;

- *Шилэн дансны цахим системд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 зарлагын гүйлгээний 25,911.0 мянга, урсгал санхүүжилтийн 35 гүйлгээний 616,106.7 мянган төгрөгийг мэдээлээгүй байна.*

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4⁵, 6.4.5⁶-т заасныг зөрчиж тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна;

¹ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

² төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах

³ Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай

⁴ энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;

⁵ таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;

⁶ цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Түлш халаалтын зардлаас 560.0 мянган төгрөгийн засварын материал, цэвэр бохир усны зардлаас 296.0 мянган төгрөгийн модны суулгац тус тус худалдан авч авсан төсвийн эдийн засгийн ангиллын дагуу захиран зарцуулаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах, зохицуулалт хийх тохиолдолд Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаал журмыг баримталж ажиллах;

2. Бараа материалын данс бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тусгай зориулалттай материал /35110/ дансанд 4,998.2 мянган төгрөгийн аж ахуйн зориулалттай /аяга, халбага сэрээ, хөлийн гишгүүр гэх мэт/ материал бүртгэсэн байна.

Өгсөн зөвлөмж: Тусгай зориулалттай материал дансанд бүртгэлтэй аж ахуйн материалыг эдийн засгийн ангиллын дагуу шилжүүлэн бүртгэх;

3. Бараа материалын данс бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайланд худалдан авсан нүүрсийг үлдэгдэлгүйгээр тайлагнаж бараа материалын тайланг үнэн зөв тайлагнаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Нүүрсний үлдэгдлийг бодитоор гаргаж, бараа материалын болон санхүүгийн тайлангийн үлдэгдлийг үнэн зөвөөр илэрхийлэх;

4. Үндсэн хөрөнгийн данс бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 39 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана" заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах;

5. Худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд Ургамлын далай ХХК-аас гэрээгээр 19,950.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн боловч харилцагч байгууллага худалдан авалтын баримтыг татварын нэгдсэн цахим системд /и баримт шивээгүй/ мэдээлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалтын мэдээллийг татварын нэгдсэн системд мэдээлсэн эсэхийг шалгах, мэдээлээгүй тохиолдолд харилцагч байгууллагад хандан системд шивүүлэх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Мөнххаан сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Цэцэрлэг	6	61,890.1					2	36,085.9	5	25,804.2
	ДҮН	6	61,890.1					2	36,085.9	5	25,804.2